**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2015 оны 06 сарын 11 өдөр Дугаар 237 Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах
тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны "Хяналтын тоо, сургалтын зардал батлах тухай" 141 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй алслагдсан нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн салбарын ажиллагсадын мэргэжил, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ажлын байрны сургалтыг Баянхонгор аймаг болон сумдуудад зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд даалгасугай.

2. Сургалтад шаардагдах зардлыг эрүүл мэнд, спортын яамны бодлогын хүрээнд хийгдэх "Өрх сумын эмч, эмнэлгийн мэргэжилтний сургалт"-ын зардлаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Ч.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Баяр/-д үүрэг болгосугай.

САЙД Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080823